

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох

Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.09.24 № 46
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.ЧИМЭДДУЛАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн 5 дугаар сургуулийн 2023 оны үйл ажиллагааны зардалд зарцуулахаар 3,927,068.1 мянган төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэлээр 3,649,480.3 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг 7.07 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэлийг 92.93 хувьтай тайлагнасан байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 11/4765 дугаар албан бичгээр "Ерөнхий боловсролын сургуулийн интернэт болон дотоод сүлжээний орчин /24 сарын лизингтэй үйлчилгээ/ бүрэн хангагдсан байх", "Цахим сургалт явуулах цахим анги, танхимыг бий болгож /48 сарын лизингтэй үйлчилгээ авах/, бэлтгэл ажлын хангасан байх" гэж ирүүлсэн чиглэлийн дагуу 48 сарын лизингтэй үйлчилгээгээр 84,997.0 мянган төгрөгийн 1 гэрээ, 24 сарын лизингтэй үйлчилгээгээр 26,914.0 мянган төгрөгийн 1 гэрээ байгуулан, тайлант оны өглөгийг 76,249.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжих болсноор ерөнхий боловсрол хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 10 болж, зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулах болсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тайлант онд цахим дэлгүүрээс 117,360.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Боловсрол шинжлэх ухааны яам болон орон нутгийн хөрөнгө оруулалтын хандив тусламжаар нийт 494,954.5 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Боловсрол шинжлэх ухааны газраас 79.3 хувьтай гэж үнэлж, өмнөх оноос 0.1 хувиар өссөн байна.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>432,451,788.76</u>	<u>701,117,412.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	119,518,014.67	394,470,513.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	119,518,014.67	394,470,513.65
3121	Төгрөг	119,518,014.67	394,470,513.65
31211	Төрийн сангийн харилцах	119,518,014.67	394,470,513.65
33	АВЛАГА	3,774,646.56	3,774,646.56
335	Бусад авлага	3,774,646.56	3,774,646.56
3351	Байгууллагаас авах авлага	3,774,646.56	3,774,646.56
35	БАРАА МАТЕРИАЛ	309,159,127.53	302,872,252.50
351	Түүхий эд материал	201,004,690.68	192,069,043.35
35110	Тусгай зориулалттай материал	200,589,860.68	192,069,043.35
35130	Эм боох материал	414,830.00	-
354	Хангамжийн материал	108,154,436.85	110,803,209.15
35410	Бичиг хэргийн материал	14,536,350.00	3,336,500.00
35420	Аж ахуйн материал	5,249,195.00	-
35450	Барилгын засварын материал	2,535,925.00	4,688,500.00
35470	Бусад хангамжийн материал	85,832,966.85	102,778,209.15
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,269,695,647.07</u>	<u>7,658,876,167.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,269,695,647.07	7,658,876,167.25
392	Биет хөрөнгө	6,524,272,313.59	6,916,672,833.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,362,244,290.00	6,362,244,290.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(438,418,985.63)	(559,619,917.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	435,051,662.60	734,245,152.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,708,706.04)	(196,543,252.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,005,423.18	315,635,955.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,464,142.28)	(65,320,580.34)
39209	Зам, гүүрийн байгууламж	256,076,758.48	432,716,757.12
39210	Хуримтлагдсан элэгдэл	(94,513,986.72)	(106,685,570.56)
393	Биет бус хөрөнгө	745,423,333.48	742,203,333.52
39301	Програм хангамж	10,009,502.00	10,009,502.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,466,168.52)	(8,686,168.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	740,880,000.00	740,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,702,147,435.83</u>	<u>8,359,993,579.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>76,249,600.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	76,249,600.00
413	Өглөг	-	76,249,600.00
4136	Бусад өглөг	-	76,249,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	76,249,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,702,147,435.83</u>	<u>8,283,743,979.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,702,147,435.83	8,283,743,979.96

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,332,519,503.91	4,332,519,503.91
512	Хуримтлагдсан үр дүн	(2,786,627,080.76)	(2,205,030,536.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,786,627,080.76)	(2,786,627,080.76)
51220	Тайлант үеийн үр дүн	-	581,596,544.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,156,255,012.68	6,156,255,012.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,702,147,435.83	8,359,993,579.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,364,334,576.20	4,460,544,720.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,304,176.20	556,378,220.50
120	Нийтлэг татварын бус орлого	96,304,176.20	556,378,220.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,304,176.20	556,378,220.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,019,200.00	15,323,240.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,950,883.00	7,578,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,334,093.20	533,476,580.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,268,030,400.00	3,904,166,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,072,365,500.00	3,752,435,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,072,365,500.00	3,752,435,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,905,000.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,905,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,759,900.00	151,730,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	151,730,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	186,759,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,179,962,201.98	3,870,268,835.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,179,962,201.98	3,870,268,835.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,772,339,868.45	3,519,646,747.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,080,413,988.32	2,577,107,918.81
210101	Үндсэн цалин	1,485,358,591.71	1,688,043,426.36
210102	Нэмэгдэл	440,394,386.61	717,128,862.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	634,103.00	780,799.06
210104	Урамшуулал	154,026,907.00	171,154,831.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,257,861.01	322,058,333.21
210201	Тэтгэврийн даатгал	179,142,125.92	221,891,260.05
210202	Тэтгэмжийн даатгал	21,861,951.17	25,936,558.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,731,886.19	19,105,213.46
210204	Ажилгүйдлийн даатгал	4,102,391.10	5,031,515.85

210205	Эрүүл мэндийн даатгал	40,419,506.63	50,093,785.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,178,416.47	108,886,616.33
210301	Гэрэл, цахилгаан	22,644,094.15	30,332,328.47
210302	Түлш, халаалт	27,858,936.98	48,623,088.14
210303	Цэвэр, бохир ус	34,675,385.34	29,931,199.72
2104	Хангамж, бараа материалын зардал	38,465,071.76	41,372,733.53
210401	Бичиг хэрэг	4,254,800.00	5,999,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	183,480.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,694,064.00	13,028,158.00
210408	Бараа материал акалсны зардал	7,282,727.76	22,345,395.53
2105	Нормативт зардал	1,070,050.00	710,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,070,050.00	710,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,299,675.00	45,996,321.00
210604	Урсгал засвар	24,299,675.00	45,996,321.00
2107	Томилолт, зочны зардал	202,300.00	-
210702	Дотоод албан томилолт	202,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,358,800.00	23,628,640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	848,800.00	15,493,640.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,510,000.00	8,135,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,093,705.89	399,885,644.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,633,145.00	34,206,019.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,106,547.20	40,019,285.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,354,013.69	325,660,340.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	407,622,333.53	350,622,087.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	405,158,666.00	347,926,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	301,773,000.00	281,364,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,385,666.00	66,562,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,463,667.53	2,695,387.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,463,667.53	2,695,387.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	184,372,374.22	590,275,885.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.40	8,679,341.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.40	8,679,341.03
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.40)	(8,679,341.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	184,372,373.82	581,596,544.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,279,000,483.00	3,927,068,140.00

11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,970,083.00	22,901,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,970,083.00	22,901,640.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,970,083.00	22,901,640.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,019,200.00	15,323,240.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,950,883.00	7,578,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,268,030,400.00	3,904,166,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,072,365,500.00	3,752,435,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,072,365,500.00	3,752,435,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,905,000.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,905,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,759,900.00	151,730,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	151,730,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	186,759,900.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,073,297,411.33</u>	<u>3,499,799,529.02</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,073,297,411.33	3,499,799,529.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,648,265,954.80	3,149,177,441.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,080,413,988.32	2,577,092,918.81
210101	Үндсэн цалин	1,485,459,861.71	1,688,043,426.36
210102	Нэмэгдэл	440,293,116.61	717,113,862.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	634,103.00	780,799.06
210104	Урамшуулал	154,026,907.00	171,154,831.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,257,861.01	322,058,333.21
210201	Тэтгэврийн даатгал	179,142,125.92	221,891,260.05
210202	Тэтгэмжийн даатгал	21,861,951.17	25,936,558.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,731,886.19	19,105,213.46
210204	Ажилгүйдлийн даатгал	4,102,391.10	5,031,515.85
210205	Эрүүл мэндийн даатгал	40,419,506.63	50,093,785.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,178,416.47	108,886,616.33
210301	Гэрэл, цахилгаан	22,644,094.15	30,332,328.47
210302	Түлш, халаалт	27,858,936.98	48,623,088.14
210303	Цэвэр, бохир ус	34,675,385.34	29,931,199.72
2104	Хангамж, бараа материалын зардал	16,751,392.00	2,333,610.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,751,392.00	2,333,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,550,000.00	40,148,896.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	550,000.00	-
210604	Урсгал засвар	26,000,000.00	40,148,896.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,805,300.00	23,628,640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	848,800.00	15,493,640.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,956,500.00	8,135,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,308,997.00	75,028,427.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	126,536,497.00	48,148,177.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,772,500.00	26,880,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	425,031,456.53	350,622,087.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	422,567,789.00	347,926,700.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,407,123.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	301,773,000.00	281,364,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,387,666.00	66,562,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,463,667.53	2,695,387.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,463,667.53	2,695,387.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>205,703,071.67</u>	<u>427,268,610.98</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	103,601,960.00	152,316,112.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,601,960.00	152,316,112.00
2200	Дотоод эх үүсвэрээр	103,601,960.00	152,316,112.00
222001	Тоног төхөөрөмж	103,601,960.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	152,316,112.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(103,601,960.00)</u>	<u>(152,316,112.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
250005	Төлсөн ногдол ашиг		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	102,101,111.67	274,952,498.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,518,014.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	119,518,014.67	394,470,513.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,519,503.91	6,156,255,012.68	(2,786,627,080.76)	7,702,147,435.83
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,332,519,503.91	6,156,255,012.68	(2,786,627,080.76)	7,702,147,435.83

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,519,503.91	6,156,255,012.68	(2,786,627,080.76)	7,702,147,435.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	581,596,544.13	581,596,544.13
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,519,503.91	6,156,255,012.68	(2,205,030,536.63)	8,283,743,979.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,518,014.67
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,061,444,214.00	3,652,115,641.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,659,423,014.00	3,304,188,941.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,229,658,000.00	2,899,151,252.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,870,806,800.00	2,577,092,918.81
210101	Үндсэн цалин	1,950,224,100.00	1,688,043,426.36
210102	Нэмэгдэл	744,181,700.00	717,113,862.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт		780,799.06
210104	Урамшуулал	176,401,000.00	171,154,831.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	358,851,200.00	322,058,333.21
210201	Тэтгэврийн даатгал	244,019,000.00	221,891,260.05
210202	Тэтгэмжийн даатгал	28,708,000.00	25,936,558.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,966,500.00	19,105,213.46
210204	Ажилгүйдлийн даатгал	5,741,600.00	5,031,515.85
210205	Эрүүл мэндийн даатгал	57,416,100.00	50,093,785.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,379,700.00	108,886,616.33
210301	Гэрэл цахилгаан	32,536,800.00	30,332,328.47
210302	Түлш халаалт	51,036,100.00	48,623,088.14
210303	Цэвэр бохир ус	42,806,800.00	29,931,199.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,149,200.00	40,148,896.00
210604	Урсгал засвар	40,149,200.00	40,148,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,400,000.00	2,333,610.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,333,610.00
2105	Нормативт зардал		
2107	Томиллолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,243,400.00	23,628,640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,323,300.00	15,493,640.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,920,100.00	8,135,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,711,614.00	200,464,289.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,711,614.00	200,464,289.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,881,100.00	26,880,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	402,021,200.00	347,926,700.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	402,021,200.00	347,926,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	335,458,500.00	281,364,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,562,700.00	66,562,700.00
2135	Төвлөрүүлэг		2,695,387.67
213503	Төвлөрүүлэг шилжүүлэг		2,695,387.67
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,061,444,214.00	3,927,068,140.00
132	Орон нутгаас санхүүжих	166,528,900.00	151,730,900.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,894,915,314.00	3,775,337,240.00
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,871,783,214.00	3,752,435,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,871,783,214.00	3,752,435,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,132,100.00	22,901,640.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,493,700.00	15,493,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,638,400.00	7,578,400.00
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		394,470,513.65
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
3	Төсвийн байгууллага	1	1
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	138	134
6	Удирдах ажилтан	3	3
7	Гүйцэтгэх ажилтан	117	113

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 3,252.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,523.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 729.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Сахилгын шийтгэлтэй 4 албан хаагчид 2,523.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Батлагдсан орон тоонд тусгагдаагүй хүний нөөцийн систем, шагнал, боловсон хүчинтэй холбоотой өдөр тутмын нэмэлт ажлыг хариуцахаар архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд 729.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үдийн цай хөтөлбөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн бичиг баримтад "Мэргэжлийн тогооч 3-оос доошгүй байх ба боловсон хүчний тодорхойлолтыг ирүүлэхдээ мэргэжлийн тогоочийн хувьд НД8 маягтыг 2022 оны 3 сараар ирүүлэх" гэж тусгасан байхад тендерийг үнэлэхдээ НД маягтад 2 тогоочийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1-д "Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ", 27.1.1-д "энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн бичиг баримтад тусгасан, шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6 дах хэсэг 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв, хөрөнгө зарцуулах, үндсэн хөрөнгө орлогод авах, хөрөнгө данснаас хасахтай холбоотой 7,684.1 мянган төгрөгийн 2 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	-	-										
Дүн	-											

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	4	3,252.7	1	2,523.1	1	729.6	2	-				
Дүн	4	3,252.7	1	2,523.1	1	729.6	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	1	-						1	-
Дүн	1	-						1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			